



“Ачаа тээврийн үйлчилгээ эрхэлж буй “Монголиавон энержи” ХХК-ний үйл ажиллагаанд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх тухай” хөтөлбөр

№02-07-110/02

2017 оны 03 дугаар сарын 15-ны өдөр

Нэг. Зөвлөн туслах үйлчилгээний зорилго, үндэслэл:

Мэргэжлийн хяналтын байгууллагын 2017 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу ачаа тээврийн үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай танилцаж, Монгол Улсын “Автотээврийн тухай”, “Төрийн хяналт шалгалтын тухай”, “Агаарын тухай” хуулиудын хэрэгжилт, холбогдох дүрэм, журам, улсын стандартуудыг мөрдөж ажиллах талаар зөвлөгөө өгөх, мэргэжлийн туслалцаа үзүүлэх замаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, эрсдлийг бууруулах, аюулгүй байдлыг хангуулах, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулж, холбогдох газруудад хүргүүлэхэд шалгалтын зорилго оршино.

Хоёр. Шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа:

Зөвлөн туслах үйлчилгээг автотээврийн хяналтын ахлах улсын байцаагч Ц.Хадбаатар 2017 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс 04 дүгээр сарын 20-ны өдрүүдэд үзүүлнэ.

Гурав. Зөвлөн туслах үйлчилгээнд хамрагдах объектын нэр:

Зөвлөн туслах үйлчилгээнд ачаа тээврийн үйлчилгээний “Монголианван энержи” ХХК /регистрийн дугаар-5855039/ хамрагдана.

Дөрөв. Зөвлөн туслах үйлчилгээний хүрээнд хийх ажил:

1. Дээрх аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг “Төрийн хяналт шалгалтын тухай” хуульд заасны дагуу Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын даргын 2017 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн А/39 дугаартай тушаалаар баталсан 5.22 кодтой “Ачаа тээврийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас”-аар шалгаж, объектийн эрсдэлийн түвшинг үнэлэх;

4. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг даргын А/04-А/19 дугаартай тушаал/захирамжаар батлагдсан “Агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журам”-ын хэрэгжилт;

3. Автотээврийн хэрэгслүүдийн техникийн шаардлага, тээвэрлэлтийн нөхцлийг хангасан эсэх;

4. Тээвэрлэлтийн баримт бичгийн ашиглалтын байдлыг тус тус шалгана.

5. Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газрын даргын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн А/138 дугаартай тушаалаар баталсан “Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх заавар”-ын 3.7 дахь заалтыг үндэслэн илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, эрсдэлийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар эрх зүйн болон мэргэжлийн зөвлөгөө, арга зүйн туслалцаа үзүүлнэ.

Тав. Зөвлөн туслах үйлчилгээний үр дүн:

1. Зөвлөн туслах үйлчилгээний дүнгийн талаар танилцуулга бичиж, 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор газрын холбогдох удирдлагуудад танилцуулан санал, дүгнэлтийг МХЕГ-ын Дэд бүтцийн хяналтын газарт хүргүүлнэ.

2. Зөвлөн туслах үйлчилгээний дүнгийн талаар “Олон нийтэд мэдээлэл түгээх журам”-ын дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

Хянасан:

ДЭД БҮТЦИЙН ХЯНАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

 Н.ГАНТУЛГА

Боловсруулсан:

АВТОТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААТЧ



Ц.ХАДБААТАР